



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 1/257
танай _____-ны № _____-т

Б А Я Н Х О Н Г О Р А Й М Г И Й Н
Б А Я Н Б У Л А Г С У М Ы Н З А С А Г Д А Р Г Ы Н
Т А М Г Ы Н Г А З Р Ы Н Д А Р Г А
Д.ЦЭНД-АЮУШ ТАНАА

2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлийн тайланд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж
байна.

Хавсралт 2/ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



6426070080



0800708549



ਮੇਰਾ ਮਨ ਮੇਰੇ ਮਨ ਮੇਰੇ ਮਨ

8002029





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/072/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2026 оны 02 дугаар сарын 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим
хаяг: Narangerelb@audit.gov.mn, 99009293
Ариун төгс оршхуй аудит ХХ-ны захирал,
Аудитор Г.Баялаг Утас: 99023656 Цахим хаяг:
ariuntugsorshihuiiaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор аймгийн Баянбулаг
сумын Засаг даргын Тамгын
Газрын дарга Д.Цэнд-Аюуш танаа

2026.02.25 № 2/101
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд санхүүжилт дутуу олгогдсоноос шалтгаалж хувь 10,840.0 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна

6426050316

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	222,097,473.78	424,419,825.55
33	АВЛАГА	879,504.00	13,019,551.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	360,000.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	519,504.00	13,019,551.00
35	БАРАА МАТЕРИАЛ	221,217,969.78	411,400,274.55
351	Түүхий эд материал	91,195,782.50	111,803,459.20
35110	Тусгай зориулалттай материал	91,195,782.50	111,803,459.20
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	156,320,442.00
354	Хангамжийн материал	31,783,476.28	39,261,662.35
35410	Бичиг хэргийн материал	602,730.00	602,730.00
35420	Аж ахуйн материал	3,790,000.00	1,470,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	2,605,000.00
35470	Бусад хангамжийн материал	27,390,746.28	34,583,932.35
35600	Мал амьтад	98,238,711.00	104,014,711.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,304,610,272.87	1,548,164,860.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,304,610,272.87	1,548,164,860.71
392	Биет хөрөнгө	1,247,042,072.87	1,458,494,660.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	880,128,483.00	832,341,237.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-300,487,406.22	-287,602,168.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл	399,832,345.00	580,988,625.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-146,494,262.81	-194,961,158.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	218,102,008.93	252,501,108.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-117,063,973.74	-137,715,182.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,536,210.50	71,653,797.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,002,126.65	-40,251,063.06
39214	Бусад үндсэн хөрөнгө	426,838,791.00	562,398,623.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-129,347,996.14	-180,859,156.93
393	Биет бус хөрөнгө	57,568,200.00	89,670,199.96
39301	Програм хангамж	5,510,000.00	5,510,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,342,000.00	-3,398,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	54,400,200.00	94,400,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-6,842,000.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,526,707,746.65	1,972,584,686.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	10,840,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	10,840,000.00
413	Өглөг	00.00	10,840,000.00
4136	Бусад өглөг	00.00	10,840,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	10,840,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,526,707,746.65	1,961,744,686.26
51	Засгийн газрын хувь оролцоо	1,526,707,746.65	1,961,744,686.26

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	302,128,037.00	302,128,037.00
51101	Өмч: - төрийн	302,128,037.00	302,128,037.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,209,013,813.69	1,652,327,853.30
51210	Өмнөх үеийн үр дүн	1,209,013,813.69	1,217,290,913.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	435,036,939.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,565,895.96	7,288,795.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,526,707,746.65	1,972,584,686.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,763,005,357.93	1,943,477,206.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	434,937,669.93	454,585,274.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	1,529,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	1,529,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,529,700.00
121	Хөрөнгийн орлого	433,937,669.93	453,055,574.00
1210017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ	166,726,308.93	374,102,912.00
1210018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	267,211,361.00	78,953,662.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,328,067,688.00	1,488,891,932.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,443,988.00	175,386,832.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,796,688.00	160,107,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,977,300.00	15,279,432.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,219,623,700.00	1,313,505,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,219,623,700.00	1,313,505,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,572,448,262.32	1,508,440,266.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,572,448,262.32	1,508,440,266.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,444,901,080.08	1,349,720,901.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	653,611,488.79	742,953,206.13
210101	Үндсэн цалин	399,389,879.79	440,745,180.13
210102	Нэмэгдэл	229,325,864.00	274,948,378.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,014,048.00
210104	Урамшуулал	21,075,800.00	12,197,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,819,945.00	5,047,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,855,104.31	92,912,384.00
210201	Тэтгэврийн даатгал	55,716,285.79	63,188,086.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,554,856.42	7,430,791.00

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,300,255.47	3,714,576.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,256,740.83	3,714,575.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,026,965.80	14,864,356.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,758,685.66	51,440,855.38
210301	Гэрэл, цахилгаан	7,725,310.46	11,828,294.38
210302	Түлш, халаалт	24,157,375.20	38,790,065.00
210303	Цэвэр, бохир ус	876,000.00	822,496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	139,555,421.00	67,088,574.93
210401	Бичиг хэрэг	3,203,780.00	4,315,600.00
210402	Тээвэр, шатахуун	30,465,580.00	23,997,939.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	696,600.00	2,339,000.00
210404	Ном, хэвлэл	211,500.00	792,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,461,750.00	6,178,222.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	789,000.00	1,762,500.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	22,803,313.93
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	100,727,211.00	4,900,000.00
2105	Нормативт зардал	374,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	374,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,229,000.00	19,111,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,794,400.00	00.00
210604	Урсгал засвар	35,434,600.00	19,111,890.00
2107	Томилолт, зочны зардал	7,494,000.00	5,770,000.00
210701	Гадаад албан томилолт	80,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	7,414,000.00	5,770,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	219,974,473.50	102,595,817.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	216,068,706.50	98,926,597.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,367.00	604,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,442,400.00	2,185,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	269,048,906.82	267,848,173.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,555,516.00	73,310,249.57
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,493,390.82	194,537,924.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,547,182.24	158,719,364.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,630,312.00	25,876,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	3,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,876,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,280,312.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,350,000.00	00.00

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	519,504.00
213304	Хөрөнгийн	00.00	519,504.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	89,916,870.24	132,323,760.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,916,870.24	132,323,760.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	190,557,095.61	435,036,939.61
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	190,557,095.61	435,036,939.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,344,175,592.00	1,490,421,632.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	1,529,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	1,529,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	1,529,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,529,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,343,175,592.00	1,488,891,932.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	123,551,892.00	175,386,832.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,670,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,796,688.00	160,107,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,977,300.00	15,279,432.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,219,623,700.00	1,313,505,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,219,623,700.00	1,313,505,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,223,022,992.00	1,375,321,404.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,223,022,992.00	1,375,321,404.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,906,305.76	1,204,101,992.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	653,750,701.20	738,670,065.13
210101	Үндсэн цалин	352,694,907.68	345,077,607.00
210102	Нэмэгдэл	260,649,601.52	325,121,249.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,738,187.00
210104	Урамшуулал	25,342,214.00	25,300,205.43
210105	Гэрээт ажлын хөлс	15,063,978.00	26,432,816.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,075,891.90	92,912,384.00
210201	Тэтгэврийн даатгал	55,758,381.60	63,188,086.00

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	6,461,197.50	7,430,791.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,476,660.05	3,714,576.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,354,483.75	3,714,575.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,025,169.00	14,864,356.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,755,685.66	51,618,359.38
210301	Гэрэл, цахилгаан	6,969,316.46	11,828,294.38
210302	Түлш, халаалт	24,910,369.20	38,790,065.00
210303	Цэвэр, бохир ус	876,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,059,430.00	41,285,179.00
210401	Бичиг хэрэг	2,730,800.00	3,818,700.00
210402	Тээвэр, шатахуун	19,827,578.00	22,778,483.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,175,000.00	2,361,200.00
210404	Ном, хэвлэл	461,500.00	1,041,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,954,552.00	9,499,996.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	910,000.00	1,785,800.00
2105	Нормативт зардал	400,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,070,000.00	12,619,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,070,400.00	00.00
210604	Урсгал засвар	44,999,600.00	12,619,390.00
2107	Томилолт, зочны зардал	6,644,000.00	5,770,000.00
210702	Дотоод албан томилолт	6,644,000.00	5,770,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	170,782,581.00	134,527,323.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,516,714.00	130,467,103.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,867.00	495,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	172,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,964,000.00	2,185,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,368,016.00	126,699,292.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,368,016.00	126,699,292.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,436,374.24	145,343,311.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,680,312.00	25,876,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	3,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	22,876,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,280,312.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	00.00

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	90,436,374.24	145,343,311.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,916,870.24	132,323,760.49
213404	Хөрөнгийн	519,504.00	13,019,551.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	121,152,600.00	115,100,228.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	121,152,600.00	115,100,228.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	121,152,600.00	115,100,228.00
2200	Дотоод эх үүсвэрээр	121,152,600.00	115,100,228.00
220001	Барилга байгууламж	00.00	91,110,628.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	121,152,600.00	23,989,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-121,152,600.00	-115,100,228.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	302,128,037.00	15,565,895.96	1,209,013,813.69	1,526,707,746.65
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	302,128,037.00	15,565,895.96	1,209,013,813.69	1,526,707,746.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,277,100.00	8,277,100.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	302,128,037.00	15,565,895.96	1,217,290,913.69	1,534,984,846.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-8,277,100.00	00.00	-8,277,100.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	435,036,939.61	435,036,939.61
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	302,128,037.00	7,288,795.96	1,652,327,853.30	1,961,744,686.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,374,766,800.00	1,126,901,945.51	247,864,854.49	82.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,374,766,800.00	1,126,901,945.51	247,864,854.49	82.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,348,490,700.00	1,101,025,845.51	247,464,854.49	81.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	743,466,700.00	738,670,065.13	4,796,634.87	99.4%
210101	Үндсэн цалин	346,588,900.00	345,077,607.00	1,511,293.00	99.6%
210102	Нэмэгдэл	327,690,100.00	325,121,249.00	2,568,851.00	99.2%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,738,800.00	16,738,187.00	613.00	100.0%
210104	Урамшуулал	25,772,900.00	25,300,205.43	472,694.57	98.2%
210105	Гэрээт ажлын хөлс	26,676,000.00	26,432,816.70	243,183.30	99.1%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,933,300.00	92,912,384.00	20,916.00	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	63,194,600.00	63,188,086.00	6,514.00	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	7,434,600.00	7,430,791.00	3,809.00	99.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,717,400.00	3,714,576.00	2,824.00	99.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,717,400.00	3,714,575.00	2,825.00	99.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	14,869,300.00	14,864,356.00	4,944.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,891,300.00	49,219,593.38	1,671,706.62	96.7%
210301	Гэрэл, цахилгаан	13,500,000.00	11,828,294.38	1,671,705.62	87.6%
210302	Түлш, халаалт	36,391,300.00	36,391,299.00	1.00	100.0%
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	49,025,700.00	39,597,690.00	9,428,010.00	80.8%
210401	Бичиг хэрэг	5,650,000.00	3,749,200.00	1,900,800.00	66.4%
210402	Тээвэр, шатахуун	27,880,000.00	21,686,694.00	6,193,306.00	77.8%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,555,700.00	2,099,000.00	456,700.00	82.1%
210404	Ном, хэвлэл	1,100,000.00	777,000.00	323,000.00	70.6%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,600,000.00	9,499,996.00	100,004.00	99.0%
210406	Бага үнэтэй,	2,240,000.00	1,785,800.00	454,200.00	79.7%

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс				
2105	Нормативт зардал	1,000,000.00	0.00	1,000,000.00	0.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	0.00	1,000,000.00	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,570,700.00	28,018,990.00	10,551,710.00	72.6%
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000,000.00	15,399,600.00	1,600,400.00	90.6%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	0.00	1,000,000.00	0.0%
210604	Урсгал засвар	20,570,700.00	12,619,390.00	7,951,310.00	61.3%
2107	Томилолт, зочны зардал	10,800,000.00	5,770,000.00	5,030,000.00	53.4%
210702	Дотоод албан томилолт	10,800,000.00	5,770,000.00	5,030,000.00	53.4%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	285,403,000.00	143,117,323.00	142,285,677.00	50.1%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	279,795,000.00	139,057,103.00	140,737,897.00	49.7%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	0.00	100.0 %
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.0 %
210804	Тээврийн хэрэгслийн татвар	518,400.00	495,220.00	23,180.00	95.5%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	290,000.00	80,000.00	210,000.00	27.6%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,500,000.00	2,185,000.00	1,315,000.00	62.4%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,400,000.00	3,719,800.00	72,680,200.00	4.9%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,400,000.00	3,719,800.00	72,680,200.00	4.9%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,276,100.00	25,876,100.00	400,000.00	98.5%
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,276,100.00	25,876,100.00	400,000.00	98.5%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,400,000.00	3,000,000.00	400,000.00	88.2%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,876,100.00	22,876,100.00	0.00	100.0 %
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,374,766,800.00	1,315,034,800.00	59,732,000.00	95.7%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,373,766,800.00	1,313,505,100.00	60,261,700.00	95.6%
132001	Орон нутгийн төсвөөс	1,373,766,800.00	1,313,505,100.00	60,261,700.00	95.6%

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,529,700.00	-529,700.00	153.0 %
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,529,700.00	-529,700.00	153.0 %
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Данс ны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	175,386,832.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	175,386,832.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮАРДАЛ	71,256,653.00
210302	Түлш халаалт	2,398,766.00
210401	Бичиг хэрэг	69,500.00
210402	Тээвэр шатахуун	1,091,789.00
210403	Шуудан холбоо	262,200.00
210404	Ном хэвлэл	264,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,170,398.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	91,110,628.00
22001	Биет болон биет бус худалдан авах	91,110,628.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,019,551.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	13,019,551.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	175,386,832.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	175,386,832.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,107,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,279,432.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хэрэгжүүлэн ажилладаг сумын Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах,

хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй ажилладаг.

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ нь орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологи нэвтэрсэн өндөр мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчний чадварт түшиглэн төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгын хүрээнд тайлант онд дараах 12 зорилт 50 арга хэмжээг хэрэгжүүлэн санхүү алба, хөдөө аж ахуйн тасаг, байгаль орчны алба, захиргаа аж ахуй 4 албатай 24 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Д.Цэнд-Аюуш, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Чимэдцэеэ нар зурж, нярваар Ч.Чулуунбат нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх

итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ нь 2025 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,972,568.1 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 445.860.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	222,097.4	424,419.9	202,322.5
Авлага	879.5	13,019.6	12,140.1
Бараа материал	221,217.9	411,400.3	190,182.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,304,610.3	1,548,164.8	243,554.5
Үндсэн хөрөнгө	2,043,348.0	2,399,793.6	356,445.6
Хуримтлагдсан элэгдэл	(738,737.7)	(851,628.7)	(112,891.0)
Нийт хөрөнгө	1,526,707.7	1,972,584.7	445,877.0
Өр төлбөр	0,00	10,840.0	(10,840.0)
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	1,526,707.7	1,961,744.7	435,037.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,526,707.7	1,972,584.7	445,877.0

Дээрх хүснэгтээс харахад, авлага дансны үлдэгдэл 13,019.6 мянган төгрөг байгаа нь 2025 оны 12 дугаар сарын эцэст нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн 12,140.1 мянган төгрөгийн авлагыг тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 411,400.3 мянган төгрөг болж өмнөх оноос 190,182.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 150,593.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар төсвийн байгууллагаас 5,710.5 мянга, бусад байгууллагаас 29,972.0 мянган төгрөгийн бараа материал, төлийн орлого 20,850.0 мянга, малын нас дэвшилтийн зөрүүнд 16,520.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч, үйл ажиллагаандаа 156,247.5 мянга, эрх бүхий байгууллагын тушаал, шийдвэрээр акталж устгасан 15,220.3 мянга, малын дэвшилтийн зөрүүнд 18,316.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,399,793.6 мянган төгрөг болж 356,445.6 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд төсвийн хөрөнгөөр 63,989.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж, эрх бүхий байгууллагын тушаал шийдвэрээр үнэ төлбөргүйгээр 374,102.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 7 дугаар хуралдааны 42 тогтоолоор 81,646.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,840.0 мянган төгрөг байгаа нь 2025 оны 11 дүгээр сарын санхүүжилт дутуу орсноос Гурван тайга ХХК-д газрын хянан баталгааны төлбөрт 10,000.0 мянга, Хаш дэвжих ай би ХХК-д барааны материалын тооцоо 840.0 мянган төгрөгийн өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 435,037.0 мянга, мянган төгрөгөөр өсөж 1,961,744.7 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,181,729.4 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга нийт 1,182,729.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэх, нийт зарлагыг 1,182,729.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 1 удаа тодотгол хийж орон нутгийн төсвөөс 1,181,729.6 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянга нийт 1,182,729.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээр санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,374,766.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,374,766.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,126,901.9 мянган төгрөг буюу 81.9 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 247,864.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсөв					
1	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,374,766.8	1,126,901.9	247,864.9	81,9%

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	921,331.0	856,908.7	64,422.3	93,0%
1.2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	144,264.7	141,125.3	3,139.8	97,8%
1.3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	25,876.1	25,876.1	00.00	100,0%
1.4	80112 Орон нутгийн нөөц	60,000.0	50,592.8	9,407.2	84,3%
1.5	81518 Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	35,000.0	34,170.2	829.8	97,6%
1.6	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	171,295.0	58,249.2	113,045.9	34,0%
1.7	82212 Хур хог хаягдал орчны бохирдлыг устгах зардал	9,000.0	8,999.9	0.1	99,9%
1.8	82310 Гамшгаас сэргийлэх сургалт	8,000.0	5,259.2	2,740.8	65,7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 64,422.3 мянга буюу 7.0 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 3,139.8 мянга буюу 2,2 хувь, орон нутгийн нөөц хөрөнгөөс 9,407.2 мянга буюу 15.7 хувь, мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардлаас 829.8 мянга буюу 2.4 хувь, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 113,045.9 мянга буюу 66.0 хувь, хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зардлаас 0.1 мянга буюу 0.1 хувь, гамшгаас сэргийлэх сургалтын зардлаас 2,740.8 мянга буюу 34.3 хувь нийт 193,585.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс дутуу санхүүжүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 160,107.4 мянган, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,279.4 мянган, нийт 175,386,8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилт 91,110.6 мянган төгрөг орсныг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн, түлш халаалтын зардалд 2,398.7 мянга, бичиг хэргийн зардал 69.5 мянга, тээвэр шатахууны зардалд 1,091.8 мянга, шуудан холбооны зардалд 262.2 мянга, ном хэвлэлийн зардалд 264.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 67,170.5 мянга, нийт 162,367.3 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн төвлөрөн төвлөрүүлэлт 13,019.5 мянган төгрөг татуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. 2025 оны 02 дугаар сард байгууллагын дотоод журамд өдөрт нэг ажилтанд 2.0 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлт олгохоор тооцож, 2025 онд батлагдсан төсөв 8,000.3 мянган төгрөг, гүйцэтгэлээр 16,378.1 мянган төгрөг зарцуулсан байна.

2. Санхүүгийн тооцоолох группийн ACOLOURS программ хангамжийн 2009 онд анх ашиглаж эхэлсэн, анхны өртөг 250.0 мянган төгрөг, 2025 онд нэмэлт хөгжүүлэлтээр 33.0 мянган төгрөг зарцуулсан. Автомат худгийн удирдлагын программ Баялаг говь ХХК-аас 2022 онд анх ашиглаж эхэлсэн. Анхны өртөг 5,280.0 мянган төгрөг зарцуулсан.

3. Сургалт, хурал зөвлөгөөнд 2024 онд батлагдсан төсөв 1,331.4 мянган төгрөг, 2025 оны гүйцэтгэлээр 1 удаагийн сургалт зөвлөгөөнд 4,000.0 мянган төгрөг зарцуулсан.

4. Гадаад томилолт, хэвлэл мэдээллийн зардалд хөрөнгө төлөвлөөгүй, зарцуулалт гаргаагүй байна.

5. Байгууллагын орон тооны талаар судалгаанд 2025 онд 26 орон тоо батлагдаж, 2 орон тоог цомхотгож, төсөв 743,466.7 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 737,670.0 мянган төгрөг зарцуулсан.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Ариун төгс оршихуй аудит" ХХК-ны аудитор Д.Сүхбаатар гүйцэтгэж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсөв 1,230,502.1 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,230,502.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,457.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,843.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 168 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 3 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,374,450.9 мянган төгрөгийн 48 гүйлгээ, зарлагын 373,228.5 мянган төгрөгийн 22 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны 12 сард эхний 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийж ашиглалтын хугацаа дууссан 6 дансны нийт 520,714.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна. 2026 оны 01 дүгээр улиралд багтаан 18,341.9 мянган төгрөгийн

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
хөрөнгийг дахин үнэлэх, 502,372.2 мянган төгрөгийн хөрөнгийг актлах хүсэлтийг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 12,425.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс шилэн дансны мэдээлэл хоцроосон зөрчилд 1 албан шаардлага, 12,450.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосон байна.

Шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	0	1	0	100
Төлбөрийн акт	3	12,425.0	3	12,425.0	100
Нийт дүн	4	12,425.0	4	12,425.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.